

Н.Е.ЕДИНАРХОВА “МОНГОЛ ДАХЬ ОРОСУУД” (РУССКИЕ В МОНГОЛИИ) НОМЫН ТУХАЙ

О.Батсайхан¹

Н.Е.Единархова “Монгол дахь Оросууд” (Русские в Монголии; Основные этапы и формы экономической деятельности 1861–1921 гг.) Иркутский государственный университет 2003., 252 с.

ОХУ-ын Эрхүү хотын улсын их сургуулийн багш, хятад болон монгол оросын харилцаа судлаач, доктор Нина Евгеньевна Единархова 1861- 1921 оны хоорондох үеийн Монгол дахь Оросуудын үйл ажиллагаа, түүний дотор эдийн засгийн харилцааны асуудлуудыг нилээд түлхүү авч судлан, Монголын олон улсын харилцааны түүхэнд холбогдох сонирхолтой бүтээл туурвисан байна. Эл ном нь удиртгал, гурван бүлэг, 5 зүйл, дүгнэлт, ашигласан материал, нэр томъёоны тайлбар гэсэн хэсгээс бүтсэн байна.

Зохиогч Хүрээнд ирсэн Оросын анхны төлөөлөгч бол худалдаачид байсан бөгөөд тэд 1861 онд Оросын анхны консулыг Монголд ирэхэд тосон авч үйлчилж байсан хэмээн бичсэн буй. Тэрээр цааш нь бичихдээ “Монголын нутаг дэвсгэрт Оросын аялагчид, үйлдвэрийн эзэд, эмч, малын эмч, цэргийн офицер, хэвлэлийн ажилтан, банк санхүүгийнхан гээд олон хүмүүс зорчиж, үйл ажиллагаа явуулж байсан нь Монгол, Оросын харилцааг хөгжүүлэхэд тодорхой түлхэц өгсөн” хэмээн тэмдэглээд хамгийн олон тооны төлөөлөгчид нь худалдаачид болон үйлдвэрийн эзэд байсан бөгөөд тэд олон талын идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан гэжээ. Иймээс зохиогч өөрийн бүтээлдээ Монгол дахь оросуудын эдийн засгийн үйл ажиллагааг түлхүү тусгасан хэмээн бичжээ.

Зохиогч өөрийн судлагааны үндсэн дээр Монгол дахь Оросуудын эдийн засгийн үйл ажиллагааг шинээр үечлэн авч үзсэн нь сонирхолтой байгаа юм. Үүнд; Нэгдүгээр үе 1861–1910 онууд, энэ үед оросууд бүх Монголын газар нутагт үйл ажиллагаа явуулж байсан хэмээн дүгнэсэн байна.

Энэ үед буюу XIX зууны 60-80-аад онуудад Оросын худалдааны үйл ажиллагаа идэвхжиж, оросууд хойд болон өмнөд Монгол, Ховдын хязгаар, Барга, Урианхайн хязгаарт нэвтэрч чадсан гээд үүнийгээ баримтаар нотлох оролдлого хийсэн байна. Харин 1890-1910-аад

¹О.Батсайхан - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D), профессор

он хүртэлх үед оросууд Монголын ой мод, байгалийн баялгийг өргөнөөр ашиглах болсон. Тухайлбал, алт олборлох “Монголор” компанийн үйл ажиллагаанаас Монгол дахь Оросын төрийн ашиг сонирхол идэвхжиж ирснийг харж болно хэмээн дүгнэжээ. Бүх Монголын нутаг дэвсгэр дэх оросуудын үйл ажиллагааны талаар ийнхүү авч үзсэн нь сайшаалтай хэрэг юм.

Хоёрдугаар үе буюу 1911-1921 онуудад оросуудын үйл ажиллагаа зөвхөн Гадаад Монголын нутаг дэвсгэрт өргөн дэлгэрсэн хэмээн бичээд энэ үед Монгол дахь Оросын төрийн оролцоо мэдэгдэхүйц өссөн гэж дүгнэжээ. Энэ үед Өргөөд (уг нь 1911 оноос Нийслэл Хүрээ хэмээн албан ёсоор нэрлэх болсон О.Б) Оросын цэргийн, санхүү, гэгээрэл зэрэг асуудлаар олон тооны зөвлөхүүд ажиллаж, Монгол дахь Оросын консулын газрын тоо нэмэгдсэн байна. Энэ үе бол Орос, Хятад хоёрын хооронд Монголын статусын төлөө хийгээд эдийн засгийн байр сууриа бэхжүүлэхийн төлөө тэмцэл өрнөсөн үе болно.

ХIХ зууны сүүл ХХ зууны эхэн үеийн Монголын тухай ярихдаа Монгол гэдэг нэрийн дор ихэвчлэн Ар Монгол буюу Халх Монголыг авч үзэж ирсэн явдлыг шүүмжтэй хандсан нь тун сайшаалтай юм. Зохиогч Оросын нэрт аялагч Н.М.Пржевальский, Д.А.Клеменц, В.В.Радлов, А.М.Позднеев, П.К.Козлов, В.И.Роборовский нарын бүтээл туурвилд бичсэнийг үндэс болгон Монгол хэмээх нэрийн дор Туркестанаас Манжуур хүртэлх Хятадын хойд хилийн дагуух газар нутгийг ойлгож хэрэглэж ирснийг тэмдэглэхийн зэрэгцээ Хятадын эх сурвалжид, тухайлбал, 1820 онд Чин гүрний Гадаад хэргийн яамнаас боловсруулан баталсан Монголын газар нутаг болон монголчуудад хамаарах 715 зүйл бүхий иргэний хуулинд заахдаа; “Хятадын дотоод мужид (Хятадын цагаан хэрмээс өмнө талыг хэлж буй хэмээн зохиогч тэмдэглэсэн) буй хятад болон цэргийнхэн (манжууд хэмээн зохиогч онцлон тэмдэглэсэн буй) хийгээд бүгдэд Монголын хилийг давж орж, тариалангийн талбай хагалахыг хатуу хориглоно” гэжээ. Ийнхүү хятадын цагаан хэрмээс хойш газар нутгийг манж нар монголчуудынх хэмээн тооцож байсан гэсэн дүгнэлттэй санал нийлж байна. Энэ саналын талаар өөр үзэл бодолтой хятадууд буйг мөн тэмдэглэсэн байна.

Зохиогчийн бичсэн дүгнэлтэнд зохиолын эхэнд өгүүлсэн Монгол дахь оросуудын эдийн засгийн үйл ажиллагааны үе шатны талаар дорвитой дүгнэлт хийсэн бол улам сайн болох байлаа хэмээн бодож байна. Мөн түүнчлэн дүгнэлтийн хэсэгт Орос, Монголын харилцааг улс төрийн үүднээс үе шатанд хуваасан нь байраа олоогүй болов уу

хэмээн өчүүхэн хүн санана. Ийнхүү үе шатанд хуваан түүхийн үйл явцыг судлах нь судалгаа цэгцтэй байх сайн талтай хэдий ч чухам үе шат болгон хуваах үндэслэл тун их нотолгоо шаардагддаг зүйл байх хэмээн бодмой.

Зохиогч Эрхүү мужийн архивт буй Монголд сууж байсан Хаант Оросын ерөнхий консулын газрын архивын эх сурвалж болон бусад орос эх сурвалжуудыг өргөн ашигласан нь зохиолын ач холбогдлыг өндөрсгөхийн зэрэгцээ нэн сайшаалтай хэрэг болсон байна.

Зохиолд Монголын талын эх сурвалж, зохиолыг бага ашигласан байх бөгөөд сүүлийн жилүүдэд энэ үеийн Монгол, Хятадын эдийн засгийн харилцааг Орос, Монголын харилцаа лугаа харьцуулан судалсан бүтээл нэг бус гарсаныг дурьдах нь зүйтэй байх.

Гэвч XIX зууны сүүл XX зууны эхэн үеийн Монголын түүх, олон улсын харилцааны асуудалд холбогдол бүхий нэн сонирхолтой эл бүтээл нь Монголын түүх судлалд өөрийн хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

Дашрамд дурьдахад Оросын Эрхүү хотын улсын их сургуулийг түшиглэн буй Монгол судлал бол эртний уламжлалтай бөгөөд нилээд хүчтэй юм. Эрхүүгийн монгол судлалаас профессор Е.М.Даревская, В.В.Свинин, Ю.В.Кузьмин, Е.И.Лиштованный, С.Г.Лузьянин зэрэг олон томоохон монгол судлаачид төрөөд буй билээ.